



## **MOST PRO o.p.s.**

### **ГАДААДЫН ИРГЭДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ГАЗАР-ҮЙЛЧИЛГЭЭ СОНИРХОГЧДОД ЗОРИУЛСАН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАЛААРХИ МЭДЭЭЛЭЛ**

#### **БИД ЮУ ХИЙДЭГ ВЭ:**

Бид гадаадын иргэдэд Чехэд амар тайван хамтран амьдрах орчиныг бүрдүүлэх зорилгоор зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах замаар нийгмийн, соёлын болон хэлний бэрхшээлийг даван туулахад нь тусладаг юм.

#### **МАНАЙ ҮЙЛЧИЛГЭЭ ХЭНД ЗОРИУЛСАН БЭ:**

Пардубицэ хотод амьдарч ажиллаж буй, эрх зүйн талаар тусламж, мэдээлэл хайж байгаа гадаадын иргэд, эсвэл нийгмийн хүнд хэцүү байдлаа шийдвэрлэх хэрэгтэй буй гадаадын иргэдэд зориулсан юм.

#### **Үйлчилгээ нь мөн доорхи иргэдэд зориулагдсан**

Гадаадын иргэдийн эрх зүйн байдлын тухай хуулийн талаархи мэдээлэл хайж буй Чех улсын иргэнд зориулсан болно.

#### **Үйлчилгээ нь доорхи үйлчилгээг шаардаж буй хүмүүст зориулагдаагүй юм**

- арилжааны үйлчилгээ (жишээ нь. татвар, хөрөнгө оруулалт)
- мэргэжлийн зөвлөгчдийн үйлчилгээ, жишээ нь: клиникийн сэтгэл судлаачид ба гэр бүлийн зөвлөгч нар

#### **БИДНИЙГ ХААНААС ОЛОХ ВЭ**

#### **Та манайд ирж болно, эсвэл утсаар, имайлаар хандаж болно.**

Нээлттэй: даваа гариг 9:00 – 17:00

мягмар, лхагва, баасан гариг 9:00 – 13:00 (13:00 – 17:00 тохиролцсоны дараа)

Хаяг: **Pardubice, 17. listopadu 216**

**Ústí nad Orlicí, Místra Jaroslava Kociána 53** (тохиролцсоны дараа)

Холбоо барих: [info@mostlp.eu](mailto:info@mostlp.eu), [www.mostlp.eu](http://www.mostlp.eu)

утас: 467 771 170, 773 223 453 (чехээр), 774 412 164 (англиар), 773 546 329 (оросоор), 608 663 251 (вьетнамаар), 777 307 193 (монголоор), 724 946 001 (румынээр), 774 453 195 (болгараар)

#### **Бидэнтэй мөн ажлын байрнаас гадуур уулзаж болно.**

Ажилтан маань орчуулагчтай хамтран Пардубицэ хотын нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлэхээс гадна тохиролцсоны дараа өөр газарт, Пардубицэ аймгийн нутаг дэвсгэрт үйлчилгээ үзүүлнэ. Үйлчилгээг дээрхи утсаар тохиролцож болно.

#### **БИДНИЙ ҮНДСЭН ЗАРЧИМ**

- **Хувийн хандлага.** Бид тухайн хүн бүрийн онцлогт тохируулан түүний хэрэгцээ, төсөөллийг хүндэтгэн харьцана.
- **Хараат бус байдал.** Бид шийдвэр гаргалтын болон харилцааны эрх чөлөөг хүндэтгэнэ
- **Шударга хандлага.** Бид хүн бүхэнд шударга, хүнлэг боловсон хандана.
- **Уламжлал.** Бид 1998 оноос эхлэн туслалцаа үзүүлж байна.
- **Үнэ төлбөргүй.** Бид үйлчилгээгээ ба орчуулгаа үнэ төлбөргүй хийж байна.

#### **БИД ЯМАР ЧИГЛЭЛҮҮДЭЭР ТУСЛАЛЦАА ҮЗҮҮЛЭХ ВЭ**

- Чех улсад оршин суух талаар
- Хөдөлмөрийн хууль эрх зүйн харьцаа
- Орон сууцны зуучлал
- Эрүүл мэндийн халамж
- Эрүүл мэндийн даатгал
- Боловсрол
- Нийгмийн хангамжийн систем г. м



Бид зөвлөгөө өгч, үр чадварын сургалт явуулахаас гадна чухал байгууллагуудтай хэлэлцэхэд, эмчид үзүүлэхэд, сургууль дээр, мөн ажил олгогчтой, байр түрээслүүлэгч нартай ярилцахад дагалдан явах, орчуулах гэх мэт туслалцааг үзүүлнэ.

### **ТАНЫГ ЮУ ХҮЛЭЭЖ БАЙНА ВЭ**

Бид таны нөхцөл байдлыг шийдэхэд тань баяртай тусална. Бид танд шаардлагатай мэдээлэлийг өгч, хамтдаа хэрхэн ажиллахаа тохиролцоно. Хамтран ажиллах төлөвлөгөө гаргаж, бидний хийж чадах зүйл мөн таны зүгээс хийж болох зүйлийг тохиролцоно.

Таны хүсэлтийн дагуу хамтран ажиллах тухай гэрээг бичгээр байгуулж болно. Хэрэв шаардлагагүй бол мөн амаар тохиролцож болно.

Манай ажилтан хамтран ажиллалтын талаар бүртгэл үргэлж хийдэг. Энэ бүртгэл нь та бидний хамтран ажиллагааг сайжруулахад, таны байдлыг дээшлүүлэхэд тусалдаг билээ. Та ажилтанаас хүссэн үедээ таны бүртгэлийн талаархи мэдээллийг харуулахыг шаардаж болно. Хэрэв та ажилтанд нэрээ тэмдэглүүлэхийг хүсэхгүй байгаа бол бүртгэл нь нэргүйгээр хийгдэнэ. Үйлчилгээг хэдийд ч шалтгаан дурьдалгүйгээр дуусгаж болно.

### **БИДНИЙ БАТЛАМЖ**

- **Хүн бүрт тэгш хандана:** Бид хүн бүрт иргэний харьалал, яс үндэс, эдийн засгийн нөхцөл байдал, шашин шүтлэг ба улс төрийн үзэлийг нь үл харгалзан үйлчилнэ.
- **Хувийн мэдээллийг хамгаална:** Таны хувийн мэдээллийг бүртгэхэд танаас бичгээр зөвшөөрөл авдаг юм. Хувийн мэдээллийг өөр ямар ч хүнд задалдаггүй бөгөөд эдгээр бүртгэл мэдээлэл нь зөвхөн таны байдлыг чанартайгаар шийдвэрлэхэд, мөн байгууллагын статистик боловсруулалтанд ашиглагддаг. Гэхдээ бид хууль эрх зүйн үүрэг хүлээсэн байдаг- хэрэв та бидэнд ноцтой гэмт хэрэг хийсэнээ хэлэх юм бол бид цагдаагийн албанд мэдэгдэх үүрэгтэй юм.
- **Үнэ төлбөргүй:** Үйлчилгээ болон орчуулага нь үнэ төлбөргүй юм
- **Мэргэжлийн түвшин:** Бүх ажилтан нар шаардлагатай боловсрол ба үр чадварыг эзэмшсэн байдаг.
- **Ганцаарчилсан хандлага:** Зөвлөгөө өгөх газрын ажилтан нар таны өөрийн онцлог болон одоогийн нөхцөл байдлыг харгалзан үзнэ.
- **Асуудал шийдэлтийн ба хэлэлцээний чөлөөт байдал:** Ажилтан нар Танд олон төрлийн шийдлийг санал болгох болно. Таны асуудлын шийдвэрийг гаргах биш харин эцсийн шийдвэр нь танаас л шалтгаалах болно.
- **Үйлчилгээний чанарын талаар гомдол гаргах эрхтэй:** Хэрэв та үйлчилгээнд сэтгэл дундуур байвал гомдолыг амаар болон бичгээр гаргаж болно.
- **Өөр ажилтан авах хүсэлт гаргаж болно:** Тантай ажиллаж буй ажилтан таны сэтгэлд нийцэхгүй байвал өөр ажилтан авах санал гаргаж болно.
- **Боловсон харьцаа ба тавлаг орчин:** Үйлчилгээ нь зөвхөн тантай харьцаж буй ажилтантай эсвэл орчуулагчтай тусгай өрөөнд явагддаг. Ажилтан нар таньтай харьцаж байх хугацаандаа яриагаа тасалдуулдаггүй /утсаар эсвэл хувийн хэргээр/, таньтай үргэлж эелдэг харьцдаг юм.

### **ТАНААС ЮУ ХҮЛЭЭЖ БАЙНА ВЭ**

- Харилцан тохиролцсон үүрэг даалгаварыг гүйцэтгэх таны идэвх зүтгэл
- Зөвлөгөө өгөх газрын нээлттэй цагийн хуваарийг мөрдөх ба тохиролцсон цагаа баримтлах
- Бүх ажилтан нартай зөв боловсон харьцах

verze k 23. 4. 2017